




Чиглүүлэгчид:

ХОРЛООГИЙН ЭНХЖАРГАЛ

Хүний хөгжлийн илтгэл боловсруулах багийн Үндэсний зөвлөх



1973 онд Монгол Улсын Анагаах ухааны дээд сургуулийг хүний их эмч мэргэжлээр төгсөж, ОХУ-ын Ленинградын хүүхдийн эмчийн их сургуульд Анагаах ухааны дэд докторын зэрэг хамгаалсан. 1980-1987 онд Анагаах Ухааны дээд сургуульд багш, 1987-1991 онд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн орлогч захирал, 1992-1996 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны газрын дарга, 2000-2005 онд ДОХ-той тэмцэх Үндэсний сангийн гүйцэтгэх захирлын албыг хашиж, 2005-2012 онд Монголд НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газарт мэргэжилтнээр ажилласан.

ХАШБАТЫН БАТСАЙХАН

Монголын Залуучуудын холбооны Дэд ерөнхийлөгч



2004 онд Зохиомж дээд сургуулийг Олон улсын сэтгүүлч мэргэжлээр төгсөж, 2014 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Сэтгүүл зүйн магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр Монголын Оюутны холбооны дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгч, НҮБ-ын Залуучуудын зөвлөх хорооны зохицуулагч, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд мэргэжилтнээр тус тус ажилласан. Одоогоор Монголын Залуучуудын холбооны Дэд ерөнхийлөгч, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд дэд дарга бөгөөд Үндэсний зөвлөлийн Тамгын газрын даргаар ажиллаж байна. 2016 оноос Олон улсын оюутны байгууллагын Боловсролын хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Монголын залуучууд, оюутны байгууллагад 12 жил ажиллаж байна.

ГАНТУЛГЫН МӨНХТӨВШИН

ХАХНХЯ-ны Залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга



“Соёл-Эрдэм” дээд сургууль, Санхүү эдийн засгийн дээд сургуулийг төгссөн. Эдийн засагч, Япон хэлний багш, орчуулагч мэргэжилтэй. Бизнесийн ухааны магистр. Тэрээр Мобиком корпораци ХХК-ийн Бизнес хамтын ажиллагааны төвд Харилцагч хариуцсан менежер, Үндэсний амьдралын даатгал ХХК-ийн даатгалын газарт Даатгалын ахлах мэргэжилтэн, ХАХНХЯ-ны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт Нийгмийн даатгалын бодлого төлөвлөлт, хэтийн тооцоолол хариуцсан мэргэжилтнээр 2008-2014 онуудад ажиллаж байгаад 2014 оноос ХАХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Залуучуудын хөгжлийн хэлтсийн даргаар ажиллаж байна.

ЧИМЭДДОРЖИЙН ОТГОНБАЯР

Сангийн яамны Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга



Ч.Отгонбаяр нь Энэтхэг Улсын Шинэ Дели хотод Jawaharlal Nehru их сургуульд улс төрийн шинжлэх ухаанаар магистрийн зэрэг хамгаалсан, БНСУ-ын Сөүл хотын Төрийн бодлого, удирдлагын сургуулийн Солонгосын Хөгжлийн институтэд хөгжлийн бодлогын чиглэлээр мэргэшсэн. Тэрээр 2008 оноос хойш Сангийн яаманд ажиллаж байгаа бөгөөд одоо тус яамны Макро эдийн засгийн хэлтсийн даргаар ажиллаж байна.